Зураг 15. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 33.1 хувийг салхин цэцэг, 14.1 хувийг тэмбүү, 10.6 хувийг цусан суулга, 8.6 хувийг сүрьеэ, 7.3 хувийг заг хүйтэн, 7.3 хувийг трихомониаз, 6.9 хувийг гар хөл амны өвчин, 4.1 хувийг улаан эсэргэнэ, 1.8 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. Нийслэлд гарсан халдварт өвчин

Төрөл	хэмжих нэгж	2016	2017	2018	Өсөлт, бууралт 2017-2018	
					тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн	бодит тоо 10000 хүнд	3528 26.8	1970 14.6	1896 13.9	-74 -0.7	-3.8
Үүнээс:						
Вируст хепатит	бодит тоо 10000 хүнд	41 0.3	21 0.2	34 0.2	13 0.0	61.9
Цусан суулга	бодит тоо 10000 хүнд	106 0.8	114 0.8	201 1.5	87 0.7	76.3
Салхин цэцэг	бодит тоо 10000 хүнд	459 3.5	625 4.6	628 4.6	3 0.0	0.5
Гахай хавдар	бодит тоо 10000 хүнд	34 0.3	16 0.1	8 0.1	-8 0.0	-50.0
Сальмонеллөз	бодит тоо 10000 хүнд	3 0.0	11 0.1	8 0.1	-3 0.0	-27.3
Улаан эсэргэнэ	бодит тоо 10000 хүнд	103 0.8	90 0.7	77 0.6	-13 -0.1	-14.4
Улаан бурхан	бодит тоо 10000 хүнд	1743 13.3	- -	- -	- -	-
Хоолны хордлого	бодит тоо 10000 хүнд	2 0.0	8 0.1	4 0.0	-4 -0.1	-50.0
Ёлом	бодит тоо 10000 хүнд	17 0.1	12 0.1	13 0.1	1 0.0	8.3
Бруцеллөз	бодит тоо 10000 хүнд	0 0.0	4 0.0	1 0.0	-3 0.0	-75.0
Гар хөл амны өвчин	бодит тоо 10000 хүнд	129 1.0	54 0.4	130 1.0	76 0.6	140.7
Тэмбүү	бодит тоо 10000 хүнд	291 2.2	304 2.3	267 2.0	-37 -0.3	-12.2
Заг хүйтэн	бодит тоо 10000 хүнд	202 1.5	200 1.5	139 1.0	-61 -0.5	-30.5
Трихомониаз	бодит тоо 10000 хүнд	207 1.6	255 1.9	138 1.0	-117 -0.9	-45.9
Сүрьеэ	бодит тоо 10000 хүнд	150 1.1	189 1.4	164 1.2	-25 -0.2	-13.2
ДОХ	бодит тоо 10000 хүнд	2 0.0	2 0.0	1 0.0	-1 0.0	-50.0



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны 1-р сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 10.9 мянган байгууллагын 161.5 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 94.9 мянга (58.8%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 48.7 мянга (30.1%) нь төсөвт байгууллагын, 17.9 мянга (11.1%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 79.5 мянган хүнээр (97.0%) нэмэгджээ.


Зураг 16. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд 2018 оны 1-р сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 113.9 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 62.7 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 79.4 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 9.0 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 9.7 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 2.0 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ

Зураг 17. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас 2018 оны 1-р сард даатгуулагч, иргэдэд 81.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 76.9 хувийг тэтгэврийн, 10.1 хувийг эрүүл мэндийн, 4.2 хувийг ҮОМШӨ-ний, 6.2 хувийг тэтгэмжийн, 2.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 1-р сард 186.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ 56.0 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 76.2 хувийг өндөр насны, 9.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.1 хувийг тэжээгчээ алдсаны, 11.2 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны 1 сард 651.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 723.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 13.0 хувиар, борлуулалт 16.3 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 20.3 хувиар, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 12.5 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 23.6 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 10.2 хувиар тус тус өссөн байна.


Зураг 18. Аж үйлдвэрийн 2017-2018 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг




Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2018 оны 1 сард 651.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар 62.0 хувийг, цахилгаан дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 13.1 хувийг, боловсруулах үйлдвэрлэлт 24.9 хувийг тус тус эзэлж байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөд хүнсний үйлдвэрлэлт, тамхи үйлвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, хувцас үйлдвэрлэлт, мод, модон эдлэл үйлдвэрлэлт, цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хэвлэл болон дүү бичлэгийн үйлдвэрлэлт, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэлт, эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэлт, мебель тавилга үйлдвэрлэлт болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нөлөө үзүүлсэн байна.


Зураг 19. Махны үйлдвэрлэлт, мянган тонн




Зураг 20. Гурил үйлдвэрлэлт, мянган тонн



Зураг 21. Талх, архи дарсны үйлдвэрлэлт




Зураг 22. Нүүрс олборлолт, мянган тонн




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 277.0 тэрбум төгрөгийг дотоодод, 446.9 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

2018 оны 1 сард борлуулсан нийт бүтээгдэхүүний 61.7 хувийг экспортоор гаргасан байна. Нийт экспортын 15.3 хувийг нүүрс олборлолт, 18.8 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 50.1 хувийг төмрийн хүдэр олборлолт, 1.0 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 1.2 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.2 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 0.2 хувийг хүнсний үйлдвэрлэлт, 0.3 хувийг тамхи үйлдвэрлэлт, мод модон эдлэл болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 12.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 23. Үйлдвэрлэлт, 2016-2017 он, тэрбум төгрөг



Зураг 24. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Хүснэгт 17. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
	сая төгрөг		
Бүгд	576 768.0	651 663.9	113.0
Уул уурхай, олборлолт	357 670.2	402 294.5	112.5
Нүүрс олборлолт	74 859.1	103 932.7	138.8
Газрын тос, шатдаг хий олборлолт	86 026.6	93 088.2	108.2
Төмрийн хүдэр олборлолт	189 948.0	200 618.8	105.6
Бусад ашигт малтмал олборлолт	6 836.5	4 654.8	68.1
Боловсруулах үйлдвэрлэл	140 425.1	154 695.4	110.2
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	71 494.5	88 344.6	123.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	5 632.5	7 918.4	140.6
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7 728.8	13 768.7	178.1
Үр тарианы гурил, малын тэжээл	14 850.5	16 649.2	112.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн	8 977.1	11 459.7	127.7
Ундаа үйлдвэрлэл	34 305.6	38 548.6	112.4
Тамхи үйлдвэрлэл	2 083.3	4 538.8	2.2*
Нэхмэлийн үйлдвэрлэл	20 754.2	24 869.0	119.8
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	566.7	886.6	156.4
Арьс шир боловсруулах үйлдвэр	2 015.1	1 634.6	81.1
Мод модон эдлэл үйлдвэрлэл	931.8	1 217.8	130.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	977.8	1 562.7	159.8
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	2 358.2	2 428.3	103.0
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 753.2	4 718.8	99.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1 798.3	1 277.9	71.1
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	880.3	1 463.0	166.2
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	120.6	156.8	130.0
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	241.5	223.8	92.7
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	31 449.6	21 372.7	68.0
Цахилгаан, дулаан, усан хангамж	78 672.7	94 674.0	120.3
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	74 814.5	90 620.0	121.1
Ус ариутгал, усан хангамж	3 858.2	4 054.0	105.1

*дахин

Хүснэгт 18. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2017	2018	$\frac{2018}{2017}$ %	үүнээс: экспорт, %
	сая төгрөг			
Бүгд	622 195.1	723 912.5	116.3	61.7
Уул уурхай, олборлолт	357 707.3	449 108.6	125.6	84.8
Нүүрс олборлолт	48 233.7	84 561.0	175.3	80.9
Газрын тос, шатдаг хий олборлолт	76 286.3	84 244.6	110.4	100.0
Төмрийн хүдэр олборлолт	226 898.1	273 553.0	120.6	81.8
Бусад ашигт малтмал олборлолт	6 289.2	6 750.0	107.3	67.0
Боловсруулах үйлдвэрлэл	185 815.1	179 951.4	96.8	36.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	68 507.6	85 116.5	124.2	1.1
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	5 534.0	6 829.3	123.4	10.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 283.2	14 095.3	170.2	
Үр тарианы гурил, малын тэжээл	15 898.7	18 389.3	115.7	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	9 402.7	12 772.4	135.8	1.5
Ундаа үйлдвэрлэл	29 389.0	33 030.2	112.4	0.2
Тамхи үйлдвэрлэл	5 406.2	5 790.5	107.1	25.6
Нэхмэлийн үйлдвэрлэлт	14 476.0	14 110.7	97.5	36.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	519.8	860.5	165.5	
Арьс шир боловсруулах үйлдвэр	1 939.6	1 692.0	87.2	52.0
Мод модон эдлэл үйлдвэрлэл	984.3	1 561.9	158.7	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	971.0	1 564.4	161.1	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	2 592.5	2 423.7	93.5	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 769.0	5 031.2	105.5	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1 800.3	1 495.1	83.0	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	824.4	1 769.2	2.1*	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	197.3	113.1	57.3	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	238.2	236.6	99.3	
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	82 588.9	58 186.0	70.5	98.8
Цахилгаан, дулаан, усан хангамж	78 672.7	94 852.5	120.6	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	74 814.5	90 628.9	121.1	
Ус ариутгал, усан хангамж	3 858.2	4 223.6	109.5	

* дахин



МАЛ АЖ АХУЙ

Оны эхний малын 0.4 хувьтай тэнцэх 1589 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өсчээ. Хорогдсон нийт малын 7.6 хувийг адуу, 25.1 хувийг үхэр, 28.3 хувийг хонь, 39.0 хувийг ямаа эзэлжээ. Том малын зүй бус хорогдлын 46 нь (2.9%) өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 19. Том малын зүй бус хорогдол, дүүргээр

Дүүрэг	2014	2015	2016	2017	2018
Нийслэлийн дүн	233	129	583	760	1589
Багануур	150	69	139	277	268
Багахангай	10	10	8	-	38
Баянзүрх	22	-	24	37	138
Налайх	2	-	148	146	217
Сонгинохайрхан	25	12	208	64	871
Сүхбаатар	3	-	8	14	2
Хан-Уул	19	36	45	222	55
Чингэлтэй	2	2	3	-	-



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2018 оны эхний 1 сард нийслэлийн хүн амд 2.9 сая.м³ (78.4%), аж ахуйн нэгж, байгууллагад 0.8 сая.м³ (21.6%) цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 20. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
Шахсан ус	мянган м ³	4 755.2	4 472.9	4 463.6	4 450.2	4 619.2	103.8
Борлуулсан ус	мянган м ³	3 953.0	4 027.1	3 767.7	3 841.2	3 654.8	95.1
Хүн амд	мянган м ³	2 909.7	2 964.3	2 867.9	3 161.9	2 850.3	90.1
Аж ахуйн нэгж, байгууллагад	мянган м ³	1 043.3	1 062.8	899.8	679.3	804.5	118.4
Татан зайлуулсан бохир	мянган м ³	3 838.5	3 971.4	3 774.9	3 870.1	3 688.4	95.3
Хүн амаас	мянган м ³	2 681.5	2 789.3	2 766.1	3 056.6	2 795.8	91.5
Аж ахуйн нэгж, байгууллагаас	мянган м ³	1 157.0	1 182.1	1 008.8	813.5	892.6	109.7
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	1 400.5	2 369.0	2 186.9	2 213.4	2 260	102.1
Хүн амаас	сая төгрөг	815.4	1 362.2	1 290.1	1 430.8	1 335.8	93.4
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	585.1	1 006.8	896.8	782.6	924.2	118.1
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	777.0	1 452.1	1 502.1	1 532.6	1 540.2	100.5
Хүн амаас	сая төгрөг	395.3	620.3	671.0	758.4	711.0	93.8
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	381.7	831.8	831.1	774.2	829.2	107.1

Хүн амд түгээсэн цэвэр усны 2.8 сая.м³ (96.88%) усыг төвлөрсөн шугамаар, 88.4 мян.м³ (3.10%) усыг ус түгээх байраар, 0.5 мян.м³ (0.02) усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 5.3 сая.м³ бохир цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 3.7 сая.м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 25. Борлуулсан ус, сараар, мянган м³



Зураг 26. Татан зайлуулсан бохир, сараар, мянган м³



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2018 оны 1-р сард дунджаар -22.4°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -2.4°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал -0.9°C -аар тус тус хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм -10.0°C , хамгийн хүйтэн хэм -33.8°C , хүр тунадасны нийлбэр 1.8 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 10 метр секунд хүрч, цасан бүрхүүлийн зузаан 10 сантиметр байна.


Хүснэгт 21. Агаарын бохирдолт, мг/м³, 1-р сард²

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	282	0.167	97	0.047
Азотын давхар исэл	NO ₂	0.050	316	0.168	173	0.056
Тоосжилт	PM ₁₀	0.100	311	0.959	252	0.217
	PM _{2.5}	0.050	181	0.649	174	0.194
Нүүрстөрөгчийн дутуу исэл ³	CO	10.000	847	13.560	3	2.662
Озон	O ₃	0.100	680	0.082	-	0.021

² Эх үүсвэр: Цаг уур орчны шинжилгээний газар


³ 8 цагийн дундаж

Зураг 27. Улаанбаатар⁴ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



2018 оны 1-р сард азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 30 удаа, 13-р хороолол орчимд 25 удаа, 32-ын тойрог орчимд 24 удаа, Толгойт орчимд 23 удаа, Амгалан орчимд 20 удаа, Телевиз орчимд 19 удаа, Ургах наран хороолол орчимд 15 удаа, 1-р хороолол орчимд 10 удаа, Хархорин зах орчимд 4 удаа, Мишээл экспо төвийн орчимд 2 удаа, Офицеруудын ордон орчимд 1 удаа, хүхэрлэг хийн агууламж Амгалан орчимд 25 удаа, 32-ын тойрог болон Ургах наран хороолол орчимд тус бүр 16 удаа, 13-р хороолол орчимд 12 удаа, 1-р хороолол орчимд 11 удаа, Баруун 4 зам орчимд 9 удаа, Мишээл экспо төвийн орчимд 6 удаа, Хархорин зах орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.


Зураг 28. Улаанбаатар⁴ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³




10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 29 удаа, Хархорин зах орчимд 27 удаа, Баруун 4 зам болон Телевиз орчимд тус бүр 26 удаа, 1-р хороолол орчимд 25 удаа, Амгалан орчимд 24 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, Мишээл экспо төвийн орчимд 15 удаа, Нисэх орчимд 11 удаа, Ургах наран хороолол орчимд 6 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 31 удаа, Амгалан орчимд 30 удаа, Баруун 4 зам орчимд 26 удаа, 13-р хороолол орчимд 24 удаа, Нисэх орчимд 17 удаа, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 4 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

⁴ Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдлыг хэмжих харуул цэг байхгүй

Зураг 29. Улаанбаатар⁴ хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 30. Улаанбаатар⁴ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Хүснэгт 22. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 1-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.038	0.038	0.080	0.045	0.064	0.029	0.035	0.050	0.017	-	-	0.071
	Хамгийн их	0.095	0.068	0.167	0.081	0.145	0.044	0.065	0.097	0.030	-	-	0.110
	XXX*-с давсан хувь	19.0	29.0	58.0	39.0	64.0	-	7.0	52.0	-	-	-	81.0
	Хэмжилтийн тоо	31	31	19	31	25	25	27	31	31	-	-	31
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.039	0.117	0.059	0.071	0.062	0.030	0.036	0.056	0.025	0.060	0.057	0.056
	Хамгийн их	0.059	0.168	0.106	0.111	0.087	0.051	0.058	0.079	0.042	0.091	0.092	0.075
	XXX*-с давсан хувь	20.0	97.0	53.0	81.0	77.0	4.0	15.0	79.0	-	77.0	61.0	65.0
	Хэмжилтийн тоо	10	31	19	31	31	25	27	19	31	30	31	31
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	2.063	5.367	1.794	2.612	-	1.574	0.873	1.406	4.582	4.013	2.332
	Хамгийн их	-	7.725	11.438	4.113	7.688	-	5.725	2.625	3.145	10.470	13.560	8.844
	XXX*-с давсан хувь	-	-	3.0	-	-	-	-	-	-	1.0	1.0	-
	Хэмжилтийн тоо	-	93	37	93	93	-	73	93	93	89	90	93
Тоос PM ₁₀	Дундаж	0.144	0.214	0.398	0.189	0.346	-	0.228	0.108	0.160	0.240	0.198	0.164
	Хамгийн их	0.319	0.860	0.740	0.362	0.959	-	0.441	0.216	0.294	0.406	0.365	0.292
	XXX*-с давсан хувь	65.0	77.0	100.0	74.0	94.0	-	89.0	55.0	71.0	96.0	87.0	100.0
	Хэмжилтийн тоо	31	31	8	31	31	-	27	31	31	28	31	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.180	0.353	0.112	-	-	-	-	0.148	0.232	0.193	0.139
	Хамгийн их	-	0.523	0.649	0.194	-	-	-	-	0.266	0.379	0.357	0.261
	XXX*-с давсан хувь	-	93.0	100.0	88.0	-	-	-	-	97.0	100.0	100.0	97.0
	Хэмжилтийн тоо	-	29	6	25	-	-	-	-	31	28	31	31
Озон O ₃ **	Дундаж	0.015	-	0.048	0.013	0.005	-	-	0.027	0.021	0.018	-	0.030
	Хамгийн их	0.037	-	0.082	0.034	0.024	-	-	0.063	0.040	0.056	-	0.062
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	93	-	33	93	93	-	-	93	93	89	-	93

*- Хүлцэх хэм хэмжээ,

** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2018 оны 1-р сарын 10, 11-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж бохирдолтой, амоны азот 74.1 дахин, эрдэс фосфор 25.5 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 15.3 дахин, нитридийн нэгдлийн хэмжээ 1.1 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 23. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 1-р сард⁵

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	9.40	Хэвийн	1.44	Горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤ 3	1.3	Хэвийн	46.0	15.3 дахин
Нитридийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.005	Хэвийн	0.022	1.1 дахин
Амоны азот	NH ₄	≤0.5	0.03	Хэвийн	37.06	74.1 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.025	Хэвийн	2.548	25.5 дахин




ГЭМТ ХЭРЭГ

2018 оны 1-р сард 2971 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1232 (70.8%) хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 45.6 хувьтай байгаа нь бөмнөх оны мөн үеэс 15.9 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 510 хүн гэмтэж осолдон, 114 хүн нас барж, төр ард иргэдэд 144.9 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 0.4 тэрбум (0.3%) төгрөгийн

хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 31. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



⁵ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2018 оны I сарын танилцуулга

Бүртгэгдсэн гэмт хэргийн 39.3 хувийг хулгайн, 21.1 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 15.1 хувийг залилан, 5.3 хувийг дээрмийн, 2.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, 1.4 хувийг ашиглалтын журмын эсрэг, 0.1 хувийг танхайн хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 24. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт	
	2016	2017	2018	Тоо	Хувь
Нийт	1735	1739	2971	1232	70.8
Үүнээс:					
Хүний амь	10	6	7	1	16.7
Хүчин	11	10	26	16	160.0
Дээрэм	42	46	158	112	243.5
Хулгай	585	505	1167	662	131.1
Булаалт	13	16	- ⁶	-16	-
Залилан	169	185	449	264	142.7
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	458	528	627	99	18.8
Хөдөлгөөний аюулгүй байдал	71	78	70	-8	-10.3
ашиглалтын журам зөрчих					
Бусдыг амиа хорлоход хүргэх	65	69	122	53	76.8
Ашиглах	17	13	41	28	215.4
Танхайрах	122	118	3	-115	-97.5
Бусад	172	165	301	136	82.4

2018 оны 1-р сард 2110 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 923 (30.4%) хүнээр буурсан байна.

Хүснэгт 25. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр


Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2017-2018	
	2016	2017	2018	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	1 735	1 739	2 971	1 232	70.8
Багануур	34	17	34	17	100.0
Багахангай	4	1	2	1	100.0
Баянгол	292	328	497	169	51.5
Баянзүрх	391	411	823	412	100.2
Налайх	40	32	61	29	90.6
Сонгинохайрхан	299	252	500	248	98.4
Сүхбаатар	295	274	471	197	71.9
Чингэлтэй	214	268	320	52	19.4
Хан-Уул	166	156	263	107	68.6

⁶ Монгол Улсын зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль шинэчлэгдэн баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бусдын эд хөрөнгийг булаах үзүүлэлтийг гэмт хэргийн бүртгэлд тооцохгүй болсон.

Хүснэгт 26. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон	
Нийслэлийн дүн	2821	113	4.0
Багануур	25	2	8.0
Багахангай	2	-	-
Баянгол	469	11	2.3
Баянзүрх	784	41	5.2
Налайх	57	3	5.3
Сонгинохайрхан	469	18	3.8
Сүхбаатар	459	7	1.5
Чингэлтэй	306	18	5.9
Хан-Уул	250	13	5.2

Зураг 32. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр



2018 оны 1-р сард бүртгэгдсэн гэмт хэргийн 2172 (73.1%) нь хөнгөн хэрэг, 799 (26.9%) нь хүнд хэрэг байна.⁷ Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хамгийн өндөр (8.0%) нь Багануур дүүрэгт байгаа бол, хамгийн бага (1.5%) нь Сүхбаатар дүүрэгт байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 233 болж, өмнөх оны мөн үеэс 901 (79.5%) хүнээр буурсан байна.

оноос 4864 (33.6%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 75 (32.2%) нь согтуугаар үйлдсэн, 33 (14.2%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 9 (3.9%) нь хүүхэд, 30 (12.9%) нь эмэгтэйчүүд байна.

⁷ Монгол Улсын эрүүгийн тухай хууль шинэчлэлэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

Хүснэгт 27. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2016	2017	2018	2016	2017	2018
Нийслэлийн дүн	585	505	1 167	507	436	981
Багануур	4	5	4	4	3	3
Багахангай	1	1	1	-	1	1
Баянгол	70	63	165	56	44	138
Баянзүрх	126	122	362	106	105	265
Налайх	6	12	27	4	10	26
Сонгинохайрхан	126	69	219	119	64	215
Сүхбаатар	120	86	181	101	78	145
Чингэлтэй	87	98	131	76	87	119
Хан-Уул	45	49	77	41	44	69



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2018 оны эхний 1 сард 17 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн байна.

Нийт гамшигт хүний үйл ажиллагаатай холбоотой 17 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 1 осол, бусад төрлийн 16 осол бүртгэгджээ.

Нийслэл хотод 2018 оны эхний 1 сард ахуйн 250 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өссөн байна. Гал түймрийн улмаас 4 хүн (үүнээс, хүүхэд 0) амь насаа алдаж, 2 хүн (үүнээс, хүүхэд 0) түлэгдэж гэмтсэн байна.

Хүснэгт 28. Гал түймрийн тоо, дүүргээр


Дүүрэг	2013	2014	2015	2016	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
Нийслэлийн дүн	285	393	320	259	216	250	115.7
Багануур	1	4	3	2	3	2	66.6
Багахангай	0	1	2	1	0	1	0.0
Баянгол	43	71	39	36	43	36	83.7
Баянзүрх	64	93	80	64	38	63	165.7
Налайх	4	16	9	10	10	10	100.0
Сонгинохайрхан	66	76	66	57	52	54	103.8
Сүхбаатар	32	46	37	34	22	28	127.3
Хан-Уул	27	49	35	25	23	29	126.1
Чингэлтэй	48	37	49	30	25	27	108.0

Гал түймрийн аюулаас 86 хүн, 134 байшин барилга, 0.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 8, санамсаргүй байдлаас 128, санаатай үйлдлээр 2, шалтгаан тогтоогдоогүй 15, бусад шалтгаанаар 97 гал түймэр гарчээ.


Гал түймэрт 107 гэр, орон сууц, 22 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 21 машин техник, малын 57 хашаа, саравч, бусад төрлийн 43 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний

хувийн өмчийн 156, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 94 объект өртөж, нийт 0.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 33. Гал түймэр, байршлаар



Зураг 34. Гал түймэр, шалтгаанаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2018 оны эхний 1 сард 42 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 28 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 1163 объектод үзлэг шалгалт хийж, 5147 галын зөрчил илрүүлж, 4 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 264 заавал биелүүлэх албан шаардлага, 665 мэдэгдэл хүргүүлж, 7.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР